



**НИЙСЛЭЛИЙН
ТӨР ЗАХИРГААНЫ АВТО БААЗ УТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар А/21

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны “Нийслэл, дүүргийн орон нутгийн төсвийн байгууллага, өмчит үйлдвэрийн газрын ажиллагсдад үр дүнгийн шагнал, урамшуулал олгох журам батлах тухай” 220 дугаар тогтоол, Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын дүрмийн 2.7, Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээний 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын “Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ” шинэчлэн батлагдсантай холбогдуулан ажилтан, албан хаагчдын жилийн ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнэн, шагнал урамшуулал олгох журмыг хавсралтаар баталсугай.

2. Шинэчлэн батлагдсан журмын хэрэгжилтийг хангуулж нийт ажилтан, албан хаагчдад танилцуулан, 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаал гарсантай холбогдуулан Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын даргын “Журам батлах тухай” 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/15 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Э. БОЛОР-ЭРДЭНЭ

Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын
2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн
А/21 дүгээр тушаалын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ТӨР ЗАХИРГААНЫ АВТО БААЗ УТҮГ-ЫН ШАГНАЛ, УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь байгууллагын Төрийн үйлчилгээний албан хаагчдаас байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд тэдний оруулсан хувь нэмэр, ажлын байрны тодорхойлолтын дагуу хийсэн ажлын гүйцэтгэл, төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга, дэг журмын биелэлт зэргийг үнэлж, ажилчдыг урамшуулах, үр дүнг үнэлэх, төрийн албан хаагчдыг чадавхжуулах, хариуцлагыг дээшлүүлэх, ажиллах идэвхийг өрнүүлэхэд оршино.
- 1.2. “Шагнал” гэж Нийслэлийн Төр захиргааны авто бааз УТҮГ-ын удирдлагаас ажилтанд олгох үнэ бүхий зүйл, алдаршуулалтыг ойлгоно.
- 1.3. “Урамшуулал” гэж ажлын гүйцэтгэлийн үр дүнг үнэлж олгосон мөнгөн дүнг хэлнэ.

Хоёр. Шагнал, урамшууллын ангилал, хэмжээ

- 2.1. Байгууллагын ажилтнуудын жилийн гүйцэтгэлийн үр дүнг үнэлж олгох мөнгөн урамшууллыг тухайн үеийн байгууллагын төсөв хөрөнгө, дээд газрын шийдвэр, бусад нөхцөл байдлыг харгалзан Даргын зөвлөлийн хурлаар тогтоон Газрын даргын тушаалаар баталгаажуулна.
- 2.2. Байгууллагын ажилтнуудын жилийн төлөвлөгөөний биелэлт, ажлын бүтээмжийг үнэлж дараах шагналуудыг олгоно. Үүнд:
 - 2.2.1. “Оны хөдөлмөрийн аварга”-1,
 - 2.2.2. “Оны шилдэг ажилтан”-1,
 - 2.2.3. “Оны шилдэг залуу ажилтан”-1,
 - 2.2.4. “Оны шилдэг удирдах ажилтан”-1,
 - 2.2.5. “Баазын нэрэмжит тусгай шагнал”- 2 хүнийг тус тус шалгаруулж шагнана.
- 2.3. Шагналын хэмжээг байгууллагын Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд зааснаар тогтооно.

Гурав. Шагнал, урамшууллын шалгуур үзүүлэлт, хамрах хүрээ

- 1.1. Оны хөдөлмөрийн аварга шалгаруулах тухай
 - 1.1.1. Оны хөдөлмөрийн аварга шалгаруулах хамрах хүрээ байгууллагын үндсэн ажилтнууд болох үйлчилгээний жолооч нар байна.

1.1.2. Шалгуур үзүүлэлт нь:

№	Үйлчилгээний жолоочийн шалгуур үзүүлэлт	Үзүүлэлтийг дүгнэж гаргах, хариуцах албан тушаалтан	Авах ёстой оноо (100)	Тайлбар
1	Өөрийн хариуцаж буй тээврийн хэрэгслийг ариг гамтай хэрэглэсэн эсэх, осол, аваар, зөрчил гаргаагүй байх.	Тээвэр зохицуулалтын хэлтсийн дарга Ерөнхий инженер	10	
2	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэйд тооцогдоогүй байх.	Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга	10	
3	Ажлын байрны үндсэн шалгуур үзүүлэлт, хэлтсийн удирдах албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн дүн.	Хэлтсийн дарга нар	10	
4	Байгууллагад зохиогдож буй олон нийтийн ажилд бусдыгаа манлайлан оролцсон байх, зөв үлгэр дуурайлал үзүүлдэг байх, багийн ажиллагаатай, зэрэг нөлөөлөлтэй байх.	Хүний нөөцийн ажилтан	10	
5	Хэрэглэгчийн гомдол бүртгэлгүй байх.	Тээвэр зохицуулалтын хэлтсийн дарга, Ерөнхий инженер	10	
6	Тооцооны хуудсыг цаг хугацаанд нь хүлээлгэн өгсөн байх.	Тээвэр зохицуулалтын хэлтсийн дарга, Ерөнхий инженер	10	
7	Авто зогсоолын цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийдэг байх.	Диспетчер-механик	10	
8	Байгууллагаас хэрэгжүүлж буй сургалт, судалгаанд идэвхтэй хамрагддаг байх.	Захиргаа, хүний нөөцийн хэлтэс	10	
9	Байгууллагын төсвөөс өөрөөс хамаарах үргүй зардал гаргуулаагүй байх.	Санхүү, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Ерөнхий нягтлан бодогч	10	

10	Хамт олны үнэлгээ	Бусад ажилчид	10	
----	-------------------	---------------	----	--

1.2. Оны шилдэг ажилтан шалгаруулах тухай

1.2.1. Оны шилдэг ажилтан шалгаруулах хамрах хүрээ нь байгууллагын үндсэн ажилчид болох диспетчер-механикууд байна.

1.2.2. Шалгуур үзүүлэлт нь:

№	Диспетчер-механикийн шалгуур үзүүлэлт	Үзүүлэлтийг дүгнэж гаргах, хариуцах албан тушаалтан	Авах ёстой оноо (100)	Тайлбар
1	Парк ашиглалтыг дээшлүүлэхэд санал санаачилгатай ажилладаг байх.	Тээвэр зохицуулалтын хэлтсийн дарга, Ерөнхий инженер	10	
2	Байгууллагын эд хөрөнгөд ариг гамтай ханддаг байх.	Хэлтсийн дарга нар	10	
3	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэйд тооцогдоогүй байх.	Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга	10	
4	Ажлын байрны үндсэн шалгуур үзүүлэлт, хэлтсийн удирдах албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн дүн.	Хэлтсийн дарга нар	10	
5	Байгууллагад зохиогдож буй олон нийтийн ажилд бусдыгаа манлайлан оролцсон байх, зөв үлгэр дуурайлал үзүүлдэг байх, багийн ажиллагаатай, эерэг нөлөөлөлтэй байх.	Хүний нөөцийн ажилтан	10	
6	Байгууллагын үйл ажиллагааг хөгжүүлэх зорилгоор шинэ санал санаачилга гаргаж ажилладаг байх.	Эрх зүйн асуудал хариуцсан ажилтан	10	
7	Хэрэглэгчийн гомдол бүртгэлгүй байх.	Тээвэр зохицуулалтын хэлтсийн	10	

		дарга, Ерөнхий инженер		
8	Үйлчилгээний жолооч, захиргааны ажилчдын хоорондын харилцааг шуурхай, тасралтгүй байлгахад анхаардаг байх.	Хэлтсийн дарга нар	10	
9	Байгууллагын угтах үйлчилгээнд анхаарал хандуулсан байдал.	Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга	10	
10	Хамт олны үнэлгээ	Бусад ажилчид	10	

1.3. Оны шилдэг залуу ажилтан шалгаруулах тухай

1.3.1. Оны шилдэг залуу ажилтан шалгаруулах хамрах хүрээ нь тухайн жилд байгууллагын үндсэн ажилтан болсон **шинэ ажилчид** байна.

1.3.2. Шалгуур үзүүлэлт:

№	Шинэ ажилчдын шалгуур үзүүлэлт	Үзүүлэлтийг дүгнэж гаргах, хариуцах албан тушаалтан	Авах ёстой оноо (100)	Тайлбар
1	Байгууллагаас хэрэгжүүлж буй сургалт, судалгаанд идэвхтэй хамрагддаг байх.	Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга	10	
2	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтөйд тооцогдоогүй байх.	Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга	10	
3	Байгууллагын эд хөрөнгөд ариг гамтай ханддаг байх.	Хэлтсийн дарга нар	10	
4	Байгууллагад зохиогдож буй олон нийтийн ажилд бусдыгаа манлайлан оролцсон байх, зөв үлгэр дууриалал үзүүлдэг байх, багийн ажиллагаатай, зэрэг нөлөөлөлтэй байх.	Хүний нөөцийн ажилтан	10	
5	Харилцаа, үйлчилгээ, биеэ авч явж буй хувийн соёлч байдал.	Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга	10	
6	Өөрийн ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор тэмцээн уралдаан,	Хэлтсийн дарга нар	10	

	байгууллагаас бусад сургалт, семинарт хамрагдсан байдал.			
7	Ажлын байрны үндсэн шалгуур үзүүлэлт, хэлтсийн удирдах албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн дүн.	Хэлтсийн дарга нар	10	
8	Байгууллагын үйл ажиллагааг хөгжүүлэх зорилгоор шинэ санал санаачилга гаргаж ажилладаг байх.	Эрх зүйн асуудал хариуцсан ажилтан	10	
9	Байгууллагын нэр хүндэд хүндэтгэлтэй хандах байх.	Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга	10	
10	Хамт олны үнэлгээ	Бусад ажилчид	10	

1.4. Оны шилдэг удирдах ажилтан шалгаруулах тухай

1.4.1. Оны шилдэг ажилтан шалгаруулах хамрах хүрээ нь байгууллагын үндсэн ажилчид болох **захиргааны ажилчид** байна.

1.4.2. Шалгаруулах болзол, шалгуур үзүүлэлтийг ажилчдын саналыг харгалзан тогтооно.

1.4.3. Шалгуур үзүүлэлт:

№	Захиргааны ажилчдын шалгуур үзүүлэлт	Үзүүлэлтийг дүгнэж гаргах, хариуцах албан тушаалтан	Авах ёстой оноо (100)	Тайлбар
1	Байгууллагад зохиогдож буй олон нийтийн ажилд бусдыгаа манлайлан оролцсон байх, зөв үлгэр дуурайлал үзүүлдэг байх, багийн ажиллагаатай, зэрэг нөлөөлөлтэй байх.	Газрын дарга ажилчдын төлөөлөлтэй хамтран	10	
2	Ажлын байрны үндсэн шалгуур үзүүлэлт, хэлтсийн удирдах албан тушаалтнаас өгсөн үүрэг	Газрын дарга, хэлтсийн дарга нартай хамтран	10	

	даалгаврын биелэлтийн дүн.			
3	Харилцаа, үйлчилгээ, биеэ авч явж буй хувийн соёлч байдал.	Газрын дарга	10	
4	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэйд тооцогдоогүй байх.	Газрын дарга ЗХНХ-ийн даргатай хамтран	10	
5	Байгууллагын нэр хүндэд хүндэтгэлтэй хандах байх.	Газрын дарга	10	
6	Байгууллагын үйл ажиллагааг хөгжүүлэх зорилгоор шинэ санал санаачилга гаргаж ажилладаг байх.	Газрын дарга	10	
7	Өөрийн ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор тэмцээн уралдаан, байгууллагад хамаарахаас бусад сургалт, семинарт хамрагдсан байдал.	Газрын дарга	10	
8	Байгууллагаас хэрэгжүүлж буй сургалт, судалгаанд идэвхтэй хамрагддаг байх.	Газрын дарга Хүний нөөцийн ажилтантай хамтран	10	
9	Харилцааны доголдолгүй байх	Газрын дарга	10	
10	Хамт олны үнэлгээ	Газрын дарга, ажилчдын төлөөлөлтэй хамтран	10	

1.5. “Байгууллагын нэрэмжит тусгай шагнал”-ын болзол, шалгуур үзүүлэлтийг Газрын дарга тогтооно.

Дөрөв. Шагналд тодорхойлох, нэр дэвшүүлэх

4.1. Засгийн газрын болон Төрийн дээд шагналын болзол хангасан ажилтан, албан хаагчийн материалыг Захиргаа, хүний нөөцийн хэлтэс зохих байгууллагад Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд заасны дагуу тодорхойлж, уламжилна.

4.2. Байгууллагын шагналд нэр дэвшүүлж байгаа ажилтны нэрийг хэлтэс дотроос нэр дэвшүүлж, хэлтсийн дарга нь Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн тодорхойлно.

Тав. Бусад зүйл

5.1. Шагналд тодорхойлох мэдээлэл, материалыг хуурамчаар бүрдүүлсэн тохиолдолд Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд заасны дагуу буруутай албан тушаалтанд хариуцлага ногдуулна.

5.2. Уг журмын 2.2-т заасан шагналаар шагнагдсан ажилтнууд дараагийн жилдээ байгууллага, хамт олноо сурталчилсан 1 арга хэмжээг санаачлан зохион байгуулна.

5.3. “Оны хөдөлмөрийн аварга” болсон ажилтанд урамшуулал болгон дараагийн жилийн цалин хөлсийг ТҮ-ийн цалингийн зэрэглэлийн 5 дугаар шатлалаар цалинжуулах эсэхийг Даргын зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ. Энэ тохиолдолд уг ажилтан сахилгын шийтгэлтэйд тооцогдсон өдрөөс шийдвэр хүчингүй болно.

5.4. Шалгуур үзүүлэлтийг дүгнэх албан тушаалтан тодорхой бус нөхцөл байдал үүсвэл тухайн ажилтны дээд шатны албан тушаалтан үзүүлэлтийг дүгнэнэ.

-- оОо --